



НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ

УЛААНБААТАР ХАВРЫН БАЯР-2023"

"УЛААНБААТАР ХАВРЫН БАЯР-2023" соёл урлагийн сургуулиуд, сургалтын төвүүдийн нэгдсэн өдөрлөгт УУПК-ийн "Урлал дизайны" мэргэжлийн хамт олон амжилттай оролцож, мэргэжил, ур чадвараа сурталчиллаа.



"ДОБУ ИНЖЕНЕРИНГ" ХХК-ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА

Манай 2 байгууллага хамтын ажиллагааны хүрээнд мехатроник, цахилгаагчин зэрэг мэргэжлүүдээр суралцагч, төгсөгчдийг дадлагажуулах, ажлын байранд ур чадварыг нэмэгдүүлэх, сургалтын хөтөлбөрийг сайжруулах, мэргэжлийн багш нарын ур чадварыг дээшлүүлэхэд ажил олгогчдыг татан оролцуулах, ХЗЗ-д эрэлтэд нийцүүлсэн мэргэжилтэн бэлтгэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр боллоо



АЖИЛ ОЛГОГЧ БАЙГУУЛЛАГУУД ОЮУТНУУДТАЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ.

ЗБЖБҮА мэргэжлийн хүрээнд ажил олгогч байгууллагуудтай тогтмол хамтран ажилладаг ажлын хүрээнд Хустайн тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлал хариуцсан менежер Э.Жаргалтуяа, Хустай жуулчны баазын менежер Б.Батзаяа нар мэргэжлийн ангийн оюутнуудтай уулзалт ярилцлага хичээл хийлээ



БОГИНО ХУГАЦААНЫ СУРГАЛТААР УР ЧАДВАР ЭЗЭМШҮҮЛЛЭЭ.

Хилчин эмгтэйчүүдийн холбоотой хамтран зохион байгуулагдаж байгаа Үсчин, Бэлэг дурсгалын зүйл урлаач, Тогооч, Оёдолчин мэргэжлүүдээр түр сургалтыг амжилттай зохион байгуулж онол болон ур чадварын шалгалтуудыг "Хөдөлмөр Нийгмийн хамгаалалын сургалт, үнэлгээ судалгааны институтын захирлын 2023 оны 04 сарын 14-ны өдрийн А/175 тоот тушаалаар томилогдсон үнэлгээний баг төгсөлтийн үнэлгээг амжилттай зохион байгууллаа.



976+11350209



Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж



www.pas.mn



СУРАЛЦАГЧДЫГ ДЭМЖИХ АЖИЛЛАГАА

ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨӨХ ДУУ ХООЛОЙ

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн "Өөрчлөлтийн төлөөх дуу хоолой" клуб 04-р сарын 04-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа эхэллээ

"Бүхний түрүүнд бүгдийг эхэл бид бүгд нийгмийн эхлэл" уриатайгаар үйл ажиллагаа болон клубын дүрмээ баталж, сонирхолтой сэдвийн хүрээнд сургалтаа зохион байгууллаа.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ



Сүхбаатар Дүүргийн Эрүүл Мэндийн төвтэй хамтран "Эрүүл өсвөр-Эрүүл ирээдүй" уриан дор оюутны эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг 4-р сарын 3, 4, 5-ны өдрүүдэд сургууль дээр зохион байгуулагдаж 29 ангийн 620 суралцагчийг хамрууллаа
"Эрүүл мэнд-Эрхэм баян"



СУРАЛЦАГЧДЫН ӨӨРИЙН УДИРДЛАГА


"Монголын ирээдүй, залуусын оролцоо" чуулганд Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн Оюутны зөвлөлийн 10 суралцагч, нийгмийн ажилтнууд сургуулиа төлөөлөн оролцлоо.



"Гэрэгэ" түүх судлалын клубын үйл ажиллагааны хүрээнд "Түүхээ судлахын ач холбогдол" сэдэвт уулзалт, ярилцлага амжилттай болж өндөрлөлөө. Тус ажлын хүрээнд түүх судлаач Чимэдийн Баяраа гуайг урьж суралцагчдын сонирхсон асуултад хариулж сонирхолтой ярилцлага өрнүүлэн ХГД1а ангийн суралцагч "Цэнгэл"Цах 1а ангийн суралцагч "М.Эрдэнэбаяр" нар "Түүхээ судлахын ач холбогдол" сэдэвт илтгэлийг танилцууллаа




МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙН НИЙГЭМЛЭГИЙН ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛГӨӨН





ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨӨХ ДУУ ХООЛОЙ

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн "Өөрчлөлтийн төлөөх дуу хоолой" II-клуб "Хүн худалдаалах гэмт хэрэг хаана ч үйлдэгдэж болно" сэдвийн хүрээнд ярилцаж, дүрийн тоглолтыг сонирхолтой байдлаар зохион байгууллаа



СУРГАЛТ

"Гэрэгэ" түүх судлалын клубын үйл ажиллагааны хүрээнд Чингис хааны музейг үзэж танилцлаа



"ЭНТРЕПРЕНЁРШИП БА БИЗНЕС ЭРХЛЭХ УР ЧАДВАР" ХӨТӨЛБӨРИЙН "ДИЗАЙН СЭТГЭЛГЭЭ" төслийн 3 долоо хоногийн туршилтын сургалт эхэллээ



"АВТОМАТ РОБОТ"-2023 ТЭМЦЭЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО

Энэ жил зохион байгуулагдсан тэмцээнд ерөнхий боловсролын 28 баг, ИДС-ын 58 баг тамирчид оролцсон бөгөөд манай сургуулийн суралцагчид "Шулуун замын төрөлд" оролцож роботын гүйцэтгэл, хурд, найдвартай ажиллагаатай байдлаар 4 болон 5-р байранд шалгарч бахархам амжилтыг үзүүлээ

976+11350209

Үйлдвэрлэл Урлалын Политехник коллеж

www.pas.mn

ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨӨХ ДУУ ХООЛОЙ

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн "Өөрчлөлтийн төлөөх дуу хоолой" II-клуб танилцуулга хичээл орлоо "Өнөөдөр хичээвэл маргааш гэрэлтэнэ" уриатайгаар II-клубын дүрмээ баталж, багаар ажиллах болон клубын үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцлоо.



НАРИЙН БИЧГИЙН ДАРГА АЛБАН ХЭРГИЙН АЖИЛТАН УР ЧАДВАРЫН УРАЛДААН

Хангай мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Боловсролын Ерөнхий Газраас хамтран зохион байгуулсан "НАРИЙН БИЧГИЙН ДАРГА-АЛБАН ХЭРГИЙН АЖИЛТАН" мэргэжлийн ур чадварын "УЛСЫН XI уралдаанд" "НБДАХА" мэргэжлийн ангийн суралцагчид маань багаараа "ТЭРГҮҮН БАЙР" эзэллээ



Хувцас загвар-оёдлын мэргэжлийн дунд зохиогдог Уран учиг-2023 уралдаанд ХЗЗБ 1а, ХЗЗБ 2а ХЗЗБ 2б, ХЗЗБ 3а ангийн 14 суралцагч ОБО 1а, ОБО 1б, ОБО 2а ангийн 18 суралцагч нийт 32 суралцагч мэдлэг, ур чадвараа дайчлан амжилттай оролцлоо



